



**ХАЛДВАРТ ӨВЧИН
СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2021 оны 12 сарын 21 өдөр

Дугаар A/286.

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсэг, 45.2.1 дэх заалт, 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, 47 дугаар зүйлийн 47.1, 47.3, 47.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, Ерөнхий захирлын 2021 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн “Журам батлах тухай” А/100 дугаар тушаалын 4 дүгээр зүйлийн 4.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус төвийн 2022 онд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж бодис, оношлуур худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Дарга:	Д.Баярсайхан – Стратеги төлөвлөлт, гадаад харилцаа эрхэлсэн дэд захирал
Нарийн бичгийн дарга:	Б.Уянга - Эм зүйн албаны дарга
Гишүүд:	Б.Оюунбэлэг- ДОХ/БЗДХ-ын тасгийн эрхлэгч
	Б.Сайханхүү – Нэгдсэн лабораторийн албаны үйл ажиллагааны менежер
	Ц.Уранцэцэг- НЛА-ны чанарын менежер
	А.Шинэхүү – Эдийн засагч
	Г.Гантуяа – Эм зүйн албаны дефектар
	Ж.Өнөрмаа – Эм зүйн албаны эм зүйч
	Р.Дорждэрэм- СТСА-ны эм хариуцсан эмч
	Н.Батжаргал –Худалдан авах ажиллагааны хөтөч ТББ-ын багш /зөвшилцсөнөөр/
	Б.Анудар –Худалдан авах ажиллагааны хөтөч ТББ-ын нягтлан бодогч /зөвшилцсөнөөр/

2. Үнэлгээний хорооны гишүүдийг дэмжлэгт удирдлагаар ханган ажиллаж, худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр

бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, Үнэлгээний хорооны зөвлөмж, дүгнэлтийг Захиалагчид хугацаанд нь ирүүлэхийг Үнэлгээний хорооны дарга (Д.Баярсайхан)-д, Үнэлгээний хорооны үйл ажиллагаа хэвийн явагдах нөхцлийг бүрдүүлж, үйл ажиллагааны явцад хөтлөгдөх баримт бичгийг зохих заавар, журмын дагуу зохион бүрдүүлж, хариуцлагатай ажиллахыг Нарийн бичгийн дарга (Б.Уянга)-д тус тус даалгасугай.

3. Үнэлгээний хороонд ажиллахдаа авилга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг баримтлан хууль дээдлэн, шударга ажиллахыг Үнэлгээний хорооны нийт бүрэлдэхүүнд үүрэг болгосугай

4. Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орж ажилласан Төрийн бус байгууллагын гишүүдэд олгох урамшууллыг тооцон Худалдан авах ажиллагааны орлогоос, олгохыг Санхүү бүртгэлийн албаны дарга (Б.Пагамдулам)-д зөвшөөрсүгэй.

5. Энэ тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хүний нөөцийн албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Урантүлхүүр)-т үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Ц. Билэгтсайхан

Ц.БИЛЭГТСАЙХАН